

БАТЛАВ  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ Я.САМБУУНЯМ

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО,  
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН СЭДЭВТ АУДИТАД ЗӨВЛӨХ ШИНЖЭЭЧИЙН  
АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 06 дүгээр 20 сарын  
... -ний өдөр

Дугаар УАГ/АД-2024-20 Улаанбаатар хот

**Ажлын зорилго**

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитыг гүйцэтгэх аудитын багт мэргэжлийн сургалт, судалгаа, зөвлөгөө, мэдээллээр хангахаас гадна аудитын явцад мэргэжлийн чиглэлээр оролцож, хамтран ажиллахад чиглэгдэнэ.

**Эхлэх хугацаа:** 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

**Дуусах хугацаа:** 2024 оны 11 дугаар сарын 29-ны өдөр

**Байршил:** Засгийн газрын 4 дүгээр байр

**НЭГ ҮНДЭСЛЭЛ**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

**ХОЁР АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Аудитад хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо, хүүхэд хамгааллын үйл ажиллагааны салбарын онцлог, мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам болон Олон улсын санхүүжүүлэгч болон төрийн бус байгууллагын гаргасан зөвлөмж тайлан мэдээ, холбогдох баримт бичгүүдийн хүрээнд.

**ГУРАВ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ**

Шинжээч дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Хүүхдийн эрх, хамгаалал, үйлчилгээ, салбарын онцлогийн талаар аудитын баг, АНТАГ-ын аудиторуудад нэгдсэн ойлголтыг өгөх,	Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол,	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитыг гүйцэтгэх аудитын багт аудитад мэргэжлийн сургалт, зөвлөгөөгөөр хангахаас гадна аудитын явцад мэргэжлийн байдлаар хамтран	Алсын хараа 2050 Хүүхэд хамгааллын тухай хууль
2	Салбар дундын зохицуулалт, үйлчилгээний чанар уялдаа холбооны талаар судалгаа мэдээлэл бэлтгэж аудитын багыг мэдээллээр хангаж, хамрах хүрээг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх	Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө		Олон улсын гэрээ, конвенц, протоколууд “Хүүхдийн төлөө сан”-ийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам Бусад шаардлагатай үзүүлэлт

3	Хүүхэд хамгааллын чиглэлээр Засгийн газар болон ТББ-тай хамтран ажилласан тайлан мэдээ, судалгааны ажлын үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж аудитын багыг мэдээллээр хангах	батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээ, ажлын даалгаварт тусгасан ажлыг тус тус үндэслэнэ	оролцож ажиллахад чиглэгдэнэ.	
4	Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэгч байгууллагын орчны судалгаа хийхэд хамтран ажиллах, бодит нөхцөл байдлыг тодорхойлж дүн шинжилгээ хийх.			
5	Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар хамгаалах байр, хүүхдийн тусламжийн утас гэх мэт үйлчилгээтэй танилцах анхаарвал зохих асуудлыг эрсдэл бүхий асуудлыг тодорхойлж ажиллахад дэмжлэг өгөх			
6	Хүүхэд хамгааллын талаар Олон Улсын сайн туршлагын судалгаа, Хүүхдийн эрхийн тухай Конвенцын хэрэгжилтийн талаарх ойлголтыг аудитын багт өгөх			
7	Аудитын төлөвлөгөөг ОУ-ын стандартад нийцүүлэн боловсруулахад аудитын багт мэргэжлийн туслалцаа үзүүлэх			
8	Аудитын явцад мэргэжлийн байдлаар хамтран ажиллах			

### **ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ**

- Шинжээчийн тайлан нь албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байх /мөр хоорондын зай “single” үсгийн хэмжээ 12/ бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.

- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.

- Тайлан, дүгнэлт боловсруулахад шалгуур болгон ашигласан хууль, стандартын норм, дүрэм зэрэг мэдээллийн эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан зорилгыг хэрэгжүүлэхдээ Төрийн аудитын тухай хууль, Төрийн аудитын стандарт, аудит хийх журмыг мөрдөж Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах бөгөөд аудитын багтай хамтран ажиллаж ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн, аудитын багт мэргэжлийн сургалт, зөвлөгөөг өгч аудитын явцад мэргэжлийн байдлаар хамтран оролцож, ажлын үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бичих бөгөөд дараах үр дүн хүлээгдэж байна.

- Хүүхдийн эрх, хамгаалал, үйлчилгээ, салбарын онцлогийн талаар аудитын баг, АНТАГ-ын аудиторруудад нэгдсэн ойлголттой болсон байна,
- Салбар дундын зохицуулалт, үйлчилгээний чанар уялдаа холбооны талаар судалгаа мэдээлэл бэлтгэж аудитын багыг мэдээллээр хангаж, хамрах хүрээг тодорхойлогдсон байна,
- Хүүхэд хамгааллын чиглэлээр Засгийн газар болон ТББ-тай хамтран ажилласан тайлан мэдээ, судалгааны ажлын үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж аудитын багыг мэдээлэлтэй болсон байна,
- Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэгч байгууллагын орчны судалгаа хийхэд хамтран ажиллаж бодит нөхцөл байдлыг тодорхойлсон байна,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар хамгаалах байр, хүүхдийн тусламжийн утас гэх мэт үйлчилгээтэй танилцах анхаарвал зохих асуудлыг эрсдэл бүхий асуудлыг тодорхойлсон байна,
- Хүүхэд хамгааллын талаар Олон Улсын сайн туршлагын судалгаа, Хүүхдийн эрхийн тухай Конвенцын хэрэгжилтийн талаарх ойлголттой болсон байна,
- Аудитын төлөвлөгөөг ОУ-ын стандартад нийцүүлэн боловсруулж, үр дүнг гаргасан байна,
- Аудитын явцад мэргэжлийн байдлаар хамтран ажилласан байх.

### **ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Шинжээч нь хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн байх, салбарын онцлог болон тогтолцооны талаар мэдлэгтэй, аудитын баг болон АНТАГ-ийн албан хаагчдад сургалт хийх чадвартай, хүүхэд хамгааллын тухай хуульд туссан заалтуудын дагуу дүн шинжилгээ хийх чадвартай, тухайн салбарын талаар мэдлэг, дадлага, туршлагатай байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчийн ажлын хүрээнд мэргэшсэн, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн байх бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэх шинжээчид дараах шаардлага тавигдана. Үүнд:

- *Хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, шаардлагад нийцүүлэн судалгаа шинжилгээ хийж байсан, тухайн чиглэлээр тайлан бэлтгэх, дүгнэлт гаргах чадвартай;*
- *Хүүхэд хамгааллын чиглэлээр дагнасан зөвлөгөө, сургалт, судалгаа хийж ажиллаж байсан бол давуу тал болно;*
- *Нийгмийн хамгааллын чиглэлээр бакалавр түүнээс дээш боловсрол эзэмшсэн, хүүхэд хамгааллын чиглэлээр 10-аас дээш жил ажилласан туршлага бүхий;*

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Ажлын даалгаварт тусгасан ажлыг гүйцэтгэх шинжээч нь ажил эхлэхийн өмнө /Аудитын баг/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно мөн үе шатны ажлын явцад илэрсэн, хэрэгжүүлэх явцад үүссэн, шийдвэрлэх боломжгүй асуудал бий болсон тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

**Бүрдүүлэх материал:**

- Шинжээчийн анкет, ажлын туршлагын талаарх товч намтар, боловсролын зэргийн диплом, мэргэшлийн гэрчилгээ, үнэмлэх, сертификатын хуулбар;

**ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

**ХЯНАСАН:**

ГҮЙЦЭТГЭЛ НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ЭНХБОЛД

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.БАТЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР



Э.УУЖИМСАН